



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар А/95

Номгон

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд
хамрагдалтыг дэмжих зөвлөл байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1, 42.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх, аргачлал, маягт шинэчлэн батлах тухай” 2021 оны 12 дугаар сарын 30 -ны өдрийн А/220, А/475, А/812 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын байгууллагад холбон зуучлах үүрэг бүхий Боловсролд хамрагдалтыг дэмжих аймгийн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Зөвлөлийн дарга: аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд -Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын нарийн бичгийн дарга

Боловсрол, шинжлэх ухааны газрын сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтэн

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын эрүүл мэнд хариуцсан гишүүн

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын “Номгон” ахлах сургуулийн захирал

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбооны тэргүүн

Нарийн бичгийн дарга Боловсрол, шинжлэх ухааны газрын бага боловсрол, тэгш хамран сургалт хариуцсан мэргэжилтэн


2.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд хамрагдалтыг дэмжих аймаг, сумын зөвлөлийг удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Нийгмийн

601220235

2.

бодлогын хэлтэс (Б.Наранбаяр), Боловсрол, шинжлэх ухааны газар (Ц.Энхтөр), сумын салбар зөвлөл байгуулж, аймгийн зөвлөлтэй хамтран ажиллахыг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, уул уурхай, нийгмийн салбар хариуцсан орлогч (Ж.Мөнхсоёл)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН